



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2019 он

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	2
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон нэрсийн жагсаалт	3
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	2
Хууль, тогтоомж болон журмын хэрэгжилт	3
Аудитын тухай хуулийн хэрэгжилт.....	3
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт	3
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт.....	3
Хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолоор батлагдсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт.....	4
Статистик үзүүлэлтүүд	4
Харилцагчид, зээлдэгчид.....	5
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	5
Тархалт	5
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	7
Мөнгөн хөрөнгө.....	7
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	7
Факторингийн тооцооны авлага.....	8
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө	8
Бусад хөрөнгө болон санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага	8
Зээл.....	9
Эргэлтийн бус хөрөнгө	10
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	11
Санхүүгийн эх үүсвэр	11
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	12
Бусад эх үүсвэр	12
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	12
Төслийн зээлийн санхүүжилт	13
Бусад өр төлбөр	13
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	13
Бусад өмч, сангууд	14
Хуримтлагдсан ашиг/алдагдал.....	14
Хоёрдогч өглөг.....	14
Ашигт ажиллагаа	15
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	16
Дүгнэлт	18

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Санхүүгийн тайлангийн ерөнхий үзүүлэлтүүд.....	2
Хүснэгт 2 Харилцагчдын мэдээлэл.....	4
Хүснэгт 3 ББСБ-ын мэдээлэл	5
Хүснэгт 4 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа, үйлчилгээ	5
Хүснэгт 5 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	6
Хүснэгт 6 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	6
Хүснэгт 7 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	7
Хүснэгт 8 Активын интервал /тэрбум төгрөгөөр/.....	7
Хүснэгт 9 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	7
Хүснэгт 10 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	8
Хүснэгт 11 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	8
Хүснэгт 12 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	8

Хүснэгт 13 Бусад хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	8
Хүснэгт 14 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	9
Хүснэгт 15 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	10
Хүснэгт 16 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 17 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/	11
Хүснэгт 18 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/	12
Хүснэгт 19 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/	12
Хүснэгт 20 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/	12
Хүснэгт 21 Төслийн зээл санхүүжилт /мянган төгрөгөөр/	13
Хүснэгт 22 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 23 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 24 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	14
Хүснэгт 25 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	14
Хүснэгт 26 Хуримтлагдсан ашиг/алдагдал	14
Хүснэгт 27 Хоёрдогч өглөг /сая төгрөгөөр/	14
Хүснэгт 28 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/	15
Хүснэгт 29 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	16
Хүснэгт 30 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/	17
Зургийн жагсаалт	
Зураг 1 Зээлийн багцын чанар	9
Зураг 2 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/	10
Зураг 3 Итгэлцлийн өглөг /тэрбум төгрөгөөр/	11
Зураг 4 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	15

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2019 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 538 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 ББСБ буюу 0.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 75 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар 14 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 15 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 11 ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь, 2 ББСБ-ын үйл ажиллагааг хэсэгчлэн түдгэлзүүлж, 9 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээний давлагаанд нэгдсэн ББСБ-уудын тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 11 байна.

Хүснэгт 1 Санхүүгийн тайлангийн ерөнхий үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2018	2019	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	1,284.9	1,730.1	34.6%
Банкны салбартай харьцуулахад хувиар	3.9%	4.8%	0.9%
Нийт өөрийн хөрөнгө	977.4	1,261.2	29.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	30.0%	41.6%	11.6%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	740.6	927.0	25.2%
Банкны салбартай харьцуулахад хувиар	83.8%	120.6%	36.8%
Нийт зээл	869.2	1,233.1	41.9%
Банкны салбартай харьцуулахад хувиар	5.1%	6.9%	1.8%
Нийт орлого	259.5	352.9	36.0%
Нийт зарлага	158.4	212.8	34.3%
Цэвэр ашиг	101.1	140.2	38.7%

ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ банкны салбарын 4.8% байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр өссөн байна. 538 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны 13 банкны хувь нийлүүлсэн хөрөнгөөс 1.2 дахин их байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.7 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 34.6 хувиар буюу 445.2 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 81.7 хувийг зээлийн үлдэгдэл, пассивын өсөлтийн 41.8 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 36.0 хувиар буюу 93.4 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 34.3 хувиар буюу 54.4 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 38.7 хувиар буюу 39.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 538 ББСБ 9 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 811 үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 494 ББСБ буюу 91.6% нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба эдгээрийн 342 ББСБ буюу 69.2% нь дагнан эрхэлж байгаа бол 156 ББСБ буюу 29.0% нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 43 ББСБ буюу 27.6% нь дагнан эрхэлж байна.

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2018	2019	тоо	хувь
	Нийт ББСБ-ын тоо	539	538	-1	-0.2%
1	Зээл	492	494	2	0.4%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	349	342	-7	-2.0%
2	Факторинг	22	29	7	31.8%
3	Төлбөрийн баталгаа гаргах	18	20	2	11.1%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	3	4	1	33.3%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	25	31	6	24.0%
6	Гадаад валютын арилжаа	157	156	-1	-0.6%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	44	43	-1	-2.3%
7	Итгэлцэл	30	34	4	13.3%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	9	10	1	11.1%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	31	34	3	9.7%

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар, гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо 2.3 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл факторингийн үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 31.8 хувиар, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ өмнөх оны

Хууль, тогтоомж болон журмын хэрэгжилт

“Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх тухай” Хорооны 2017 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 88.4%-тай байна.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын төслийг шинэчлэн боловсруулан, 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, тухайн өдрийн 210 дугаар тогтоолоор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4437 дугаараар бүртгүүлсэн. Үүний дагуу ББСБ-уудын санхүүгийн тайлангийн мастер файл болон метадатаг шинэчлэн 2019 оны III улирлаас эхлэн шинэчилсэн загвараар тайлан, мэдээг хүлээн авч байна.

Аудитын тухай хуулийн хэрэгжилт

2019 оны жилийн эцсийн байдлаар Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 538 ББСБ-ын 79.4% буюу 427 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 392 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны

мөн үеэс 24.0 хувиар өссөн байна. 2019 оны жилийн эцсийн тайлан мэдээний ирц 96.7% байна.

Тайлан мэдээг ирүүлбэл зохих 538 ББСБ-аас 520 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 18 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүргийг тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 493 ББСБ-ын 91.5% буюу 451 ББСБ хэрэгжүүлж ажилласан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 201 ББСБ, 11,357 удаагийн тохиолдлоор, 981.6 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 7 ББСБ, 32 удаагийн тохиолдлоор, 4.1 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

Хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолоор батлагдсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 527 ББСБ 1,055.0 сая төгрөгийн

зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлэхээс 497 ББСБ 996.4 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн ба биелэлт 94.3% байна.

Статистик үзүүлэлтүүд

2019 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 7,712 хувь нийлүүлэгчдийн 538 ББСБ, 250 салбар нэгж, 7 төлөөлөгчийн газар, 2,962 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 2,854,530 харилцагч, 419,854 зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Хүснэгт 2 Харилцагчдын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	2,854,530	339,455	2,515,075	55,811	2,839,567	14,963	895,773	1,958,757	32,652
Үүнээс: Эмэгтэй	1,502,263	180,451	1,321,811	31,450	1,493,495	8,768	503,925	998,338	18,537
Эрэгтэй	1,347,661	154,598	1,193,063	24,100	1,341,520	6,141	391,662	955,999	14,025
Хуулийн этгээд	4,606	4,405	201	261	4,552	54	186	4,420	90
Итгэмжлэгчдийн тоо	2,146	1,799	347	-	2,145	1	221	1,925	209
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	261	234	27	-	211	50	10	251	-
Зээлдэгчдийн тоо	419,854	154,354	265,500	-	407,287	12,567	195,847	224,007	29,923
Хэвийн	352,484	137,209	215,275	-	342,292	10,192	154,880	197,604	26,999
Хугацаа хэтэрсэн	35,493	9,524	25,969	-	34,344	1,149	22,524	12,969	1,037
Чанаргүй:	31,877	7,621	24,256	-	30,651	1,226	18,443	13,434	1,887
-Хэвийн бус	14,004	2,591	11,413	-	13,329	675	9,129	4,875	408
-Эргэлзээтэй	11,009	1,935	9,074	-	10,773	236	6,707	4,302	402
- Муу	6,864	3,095	3,769	-	6,549	315	2,607	4,257	1,077
Зээлдэгчдийн насжилт	418,305	153,153	265,152	-	405,763	12,542	195,514	222,791	29,560
18-35 насны	227,453	62,737	164,716	-	222,054	5,399	126,560	100,893	12,897
36-45 насны	121,288	54,836	66,452	-	117,297	3,991	45,544	75,744	9,407
46-55 насны	51,079	24,966	26,113	-	48,647	2,432	18,075	33,004	5,377
55-аас дээш	18,478	10,607	7,871	-	17,758	720	5,335	13,143	1,879
Зээлдэгчдийн боловсрол	418,305	153,153	265,152	-	405,763	12,542	195,514	222,791	29,560
-Дээд	243,270	80,690	162,580	-	237,393	5,877	114,181	129,089	12,949
-Тусгай дунд	36,371	18,319	18,052	-	33,133	3,238	8,786	27,585	2,464
-Бүрэн дунд	123,091	45,525	77,566	-	120,769	2,322	66,294	56,797	13,188
-Дунд	13,135	6,292	6,843	-	12,370	765	6,226	6,909	718
-Бага	2,431	2,320	111	-	2,091	340	27	2,404	241

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 1.8 дахин өсөж 2,854,530, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.8 дахин өсөж 419,854-д хүрлээ.

Нийт харилцагчдын 88.1% буюу 2,515,075 нь, зээлдэгчдийн 63.2% буюу 265,500 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 11.9% буюу 339,455, зээлдэгчдийн 36.8% буюу 154,354 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч

Хүснэгт 3 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Хувь нийлүүлэгчдийн тоо	7,712	1,742	5,970	65	7,537	175	6,670	1,042	1,061
Үүнээс: Эмэгтэй	3,142	409	2,733	29	3,072	70	2,729	413	162
Эрэгтэй	4,449	1,251	3,198	32	4,351	98	3,907	542	875
Хуулийн этгээд	121	82	39	2	114	7	34	87	23
Нийт ажилтнуудын тоо	2,962	2,604	358	122	2,768	194	223	2,739	302
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	1,718	1,525	193	69	1,600	118	133	1,585	166

Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудаас 1 ББСБ цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ давхар эрхэлж байна. Хөдөө орон нутгийн 75 ББСБ 5 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 83 үйл ажиллагаа эрхэлж байна. Одоогоор үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ байхгүй байна.

Хүснэгт 4 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа, үйлчилгээ

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
ТЗ-тэй ББСБ-ын тоо	538	527	11	43	463	75	4	534	28	510
ТЗ-тэй үйлчилгээний тоо	811	0	47	43	0	83	21	790	56	755
ТЗ-тэй үйл ажиллагааны тоо	9	9	9	1	9	5	9	9	9	-
1 Зээл	493	482	11	-	420	73	4	489	28	465
2 Факторингийн үйлчилгээ	29	23	6	-	29	-	2	27	2	27
3 Төлбөрийн баталгаа гаргах	20	19	1	-	20	-	1	19	5	15
4 Төлбөр тооцооны хэргэсэл гаргах	4	1	3	-	4	-	1	3	1	3
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	31	25	6	-	31	-	2	29	1	30
6 Гадаад валютын арилжаа	156	149	7	43	149	7	3	153	9	147
7 Итгэлцлийн үйлчилгээ	34	28	6	-	33	1	3	31	3	31
8 Богино хугацаат санхүүгийн хэргэсэлд хөрөнгө оруулалт хийх	10	7	3	-	9	1	2	8	2	8
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	34	30	4	-	33	1	3	31	5	29
10 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	-	-	-	-	-	-	-	-	-

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 86.1% буюу 463 ББСБ,

байна. Гадаад валют арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 55,811 буюу нийт харилцагчдын 2.0 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн 5,970 буюу 77.4% нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,742 буюу 22.6% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 1,061 буюу 13.8% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 175 буюу 2.3% нь хөдөө орон нутгийн хувьцаа эзэмшигчид байна.

салбаруудын 70.4% буюу 176 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт

нийт ББСБ-ын 13.9% буюу 75 ББСБ, салбаруудын 29.6% буюу 74 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 5 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	75	74	149	100%
Төв аймаг	12	2	14	9.4%
Дархан-Уул аймаг	7	10	17	11.4%
Орхон аймаг	7	11	18	12.1%
Өвөрхангай аймаг	6	5	11	7.4%
Сэлэнгэ аймаг	6	4	10	6.7%
Дорнод аймаг	5	6	11	7.4%
Баянхонгор аймаг	4	4	8	5.4%
Сүхбаатар аймаг	4	2	6	4.0%
Баян-Өлгий аймаг	3	1	4	2.7%
Хөвсгөл аймаг	3	5	8	5.4%
Хэнтий аймаг	3	2	5	3.4%
Булган аймаг	2		2	1.3%
Говьсүмбэр аймаг	2	1	3	2.0%

Дорноговь аймаг	2	4	6	4.0%
Завхан аймаг	2	1	3	2.0%
Увс аймаг	2	3	5	3.4%
Архангай аймаг	1	1	2	1.3%
Говь-Алтай аймаг	1	-	1	0.7%
Дундговь аймаг	1	1	2	1.3%
Өмнөговь аймаг	1	8	9	6.0%
Ховд аймаг	1	3	4	2.7%

Хүснэгт 6 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	463	176	639	100%
Сүхбаатар дүүрэг	164	27	191	29.9%
Чингэлтэй дүүрэг	143	24	167	26.1%
Баянгол дүүрэг	68	30	98	15.3%
Баянзүрх дүүрэг	53	45	98	15.3%
Хан-Уул дүүрэг	28	20	48	7.5%
Сонгинохайрхан дүүрэг	6	24	30	4.7%
Багануур дүүрэг	1	4	5	0.8%
Налайх дүүрэг		2	2	0.3%
Сүхбаатар дүүрэг	164	27	191	29.9%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

2019 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.7 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.7 хувиар буюу 445.2 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 81.7 хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхэнтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 7 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2018 дүн	Нийт дүнд эзлэх хувь	2019 дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	1,234,705.7	96.1%	1,663,005.9	96.1%	428,300.3	34.7%
Мөнгөн хөрөнгө	315,113.9	24.5%	363,997.7	21.0%	48,883.7	15.5%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	1,837.5	0.1%	6,752.4	0.4%	4,914.9	267.5%
Зээл (цэврээр)	804,745.6	62.6%	1,151,990.9	66.6%	347,245.3	43.1%
Нийт зээл	869,222.4	67.6%	1,233,123.6	71.3%	363,901.1	41.9%
(Зээлийн эрсдэлийн сан)	64,476.9	5.0%	81,132.7	4.7%	16,655.8	25.8%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	7,292.9	0.6%	3,805.5	0.2%	-3,487.4	-47.8%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	10,223.0	0.8%	12,033.1	0.7%	1,810.1	17.7%
Бусад хөрөнгө	95,492.8	7.4%	124,295.7	7.2%	28,802.9	30.2%
Эргэлтийн бус хөрөнгө	50,191.7	3.9%	67,128.2	3.9%	16,936.5	33.7%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	61,462.4	4.8%	81,287.6	4.7%	19,825.2	32.3%
(Хуримтлагдсан элэгдэл)	11,270.7	0.9%	14,159.4	0.8%	2,888.7	25.6%
Нийт хөрөнгийн дүн	1,284,897.4	100.0%	1,730,134.2	100.0%	445,236.8	34.7%

2.5 тэрбум ба түүнээс дээш активтай 146 ББСБ-ын нийт хөрөнгийн хэмжээ 1.2 их наяд төгрөг буюу салбарын нийт активын 70.6 хувийг бүрдүүлж байна.

Харин 2.5 тэрбум хүртэлх активтай 392 ББСБ-ын 508.3 тэрбум төгрөгийн хөрөнгө салбарын нийт активын 29.4 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	849.5	52	52.2%	9.6%	5.4	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	261.1	81	16.0%	15.0%	2.7	1	3.8	1	-	-
1.9-2.5 тэрбум	129.3	60	7.9%	11.1%	-	-	-	-	-	-
1.4-1.9 тэрбум	299.5	187	18.4%	34.7%	-	-	1.4	1	1.6	1
0.6-1.4 тэрбум	69.3	64	4.3%	11.9%	4.7	6	7.5	8	3.9	4
0.6 тэрбум хүртэлх	19.8	95	1.2%	17.6%	2.0	5	11.0	51	6.6	40
НИЙТ	1,730.1	538	100%	100%	14.9	13	25.4	62	12.1	45

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн 41.0% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 34.7% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 24.3% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 9 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	364.0	336.5	27.5	11.1	354.4	9.6	13.1	337.5	26.5
Бэлэн мөнгө	149.4	148.6	0.8	10.4	143.2	6.1	0.0	147.1	2.3
Харилцах	126.3	111.7	14.7	0.7	123.4	2.9	4.5	110.2	16.1
Хадгаламж	88.3	76.2	12.1	0.0	87.8	0.5	8.6	80.2	8.1

Уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл 44.2% нь бэлэн мөнгө хэлбэрээр байгаа бол финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 2.9% нь бэлэн мөнгө хэлбэрээр, валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-ууд үйл ажиллагааны онцлогоос хамаарч мөнгөн хөрөнгийн 93.9% нь бэлэн мөнгө хэлбэрээр байршиж байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалт

2019 оны жилийн эцсийн байдлаар 17 ББСБ 6.7 тэрбум төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт татсан байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалтын 38.9% буюу 2.6 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас бүрдүүлж байгаа бол 61.1% буюу 4.1 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 23.9% буюу 1.6 тэрбум төгрөг нь хувьцаа, 16.7% буюу 1.1 тэрбум төгрөг нь өрийн бичиг байгаа бол 59.4% буюу 4.0 тэрбум төгрөг нь бусад үнэт цаасны хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 10 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	6,752.4	2,078.1	4,674.3	1.0	6,096.0	656.4	4,674.3	2,078.1	4,006.2
Хувьцаа	1,616.3	948.2	668.1	1.0	959.9	656.4	668.1	948.2	-
Өрийн бичиг	1,124.9	1,124.9	-	-	1,124.9	-	-	1,124.9	-
Бусад	4,011.2	5.0	4,006.2	-	4,011.2	-	4,006.2	5.0	4,006.2
<i>Хөрөнгө оруулалтын үнэт цаас</i>	4,125.0	39.9	4,085.2	-	4,124.0	1.0	4,085.2	39.9	4,006.2
<i>Арилжааны үнэт цаас</i>	2,627.3	2,038.3	589.1	1.0	1,972.0	655.4	589.1	2,038.3	-

Факторингийн тооцооны авлага

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл 31.8 хувиар нэмэгдсэн. Гэвч 2019 оны жилийн эцсийн байдлаар тусгай зөвшөөрөлтэй 29 ББСБ-аас Улаанбаатар хотод байршилтай, уламжлалт санхүүгийн үйл ажиллагаа явуулж байгаа 4 ББСБ 145.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 49.7 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж 3.8 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ. Факторингийн тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын 13.8% нь үйл ажиллагаа явуулж байгаа нь хангалтгүй байна.

Хүснэгт 11 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2018		2019		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
Хэвийн	7,241.0	100.0%	3,709.4	97.5%	-3,531.7	-48.8%
Хугацаа хэтэрсэн	51.4	0.7%	65.1	1.7%	13.6	26.5%
Чанаргүй	30.4	0.4%	80.8	2.1%	50.4	165.7%
Хэвийн бус	4.0	0.1%	24.7	0.6%	20.7	517.8%
Эргэлзээтэй	0.0	0.0%	31.6	0.8%	31.6	-
Муу	26.4	0.4%	24.5	0.6%	-1.9	-7.3%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	30.0	0.4%	49.7	1.3%	19.7	65.8%

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 1.8 тэрбум төгрөг буюу 0.1 хувиар өссөн дүнтэй гарчээ.

Хүснэгт 12 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	12.0	8.8	3.2	-	11.9	0.2	0.9	11.1	3.4
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	12.3	8.2	4.1	-	12.1	0.1	1.5	10.8	3.2
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	3.0	2.0	0.9	-	3.0	-	0.6	2.4	1.0
Өмчлөх бусад хөрөнгө	2.7	2.6	0.1	-	2.7	0.0	-	2.7	1.3

Бусад хөрөнгө болон санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага

Бусад хөрөнгийн 51.6% буюу 64.2 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 29.3% буюу 36.4 тэрбум төгрөг нь цэвэр авлага, 19.1% буюу 23.7 тэрбум төгрөг нь бусад актив байна. 1 ББСБ гадаад валютын своп арилжаа хийж 130.6 сая төгрөгийн санхүүгийн үүсмэл хэрэгслийн авлагын үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 13 Бусад хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
БУСАД ХӨРӨНГӨ	124.3	108.0	16.3	0.1	120.5	3.8	8.1	116.2	21.8
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	64.2	58.3	5.9	-	63.1	1.1	3.0	61.2	11.8
-Үнэт цаасны	3.0	3.0	-	-	3.0	-	-	3.0	1.5
-Зээлийн	58.6	53.9	4.7	-	57.5	1.1	2.0	56.6	10.2
-Факторингийн	0.0	0.0	-	-	0.0	-	-	0.0	-
-Бусад	2.6	1.4	1.2	-	2.6	-	1.0	1.6	0.0
Авлага /цэврээр/	36.4	29.9	6.5	0.0	34.4	2.0	3.1	33.3	3.5

Нийт авлага	37.8	30.7	7.1	0.0	35.8	2.0	3.2	34.6	3.9
Хэвийн	35.8	29.3	6.5	0.0	33.8	2.0	3.1	32.7	3.5
Хугацаа хэтэрсэн	0.5	0.5	0.0	0.0	0.5	0.0	-	0.5	0.1
Чанаргүй:	1.5	1.0	0.6	-	1.5	0.0	0.0	1.5	0.4
-Хэвийн бус	0.1	0.1	-	-	0.1	0.0	-	0.1	0.0
-Эргэлзээтэй	0.2	0.2	-	-	0.2	0.0	-	0.2	0.0
-Муу	1.3	0.7	0.6	-	1.3	0.0	0.0	1.2	0.4
Нийт авлага (валютын)	2.8	2.7	0.1	-	2.8	-	0.1	2.7	0.3
Нийт авлага (төгрөгийн)	34.9	28.0	6.9	0.0	33.0	2.0	3.0	31.9	3.6
(Авлагын эрсдэлийн сан)	1.4	0.8	0.6	-	1.4	0.0	0.0	1.3	0.4
Бусад актив	23.7	19.7	4.0	0.1	23.0	0.7	2.0	21.7	6.5
САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЭЛ (ДЕРИВАТИВ)-ИЙН АВЛАГА	0.1	-	0.1	-	0.1	-	0.1	-	-

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 41.9% буюу 363.9 тэрбум төгрөгөөр өсөж 2019 оны жилийн эцсийн байдлаар 1,233.1 тэрбум төгрөгт хүрсэн бол 81.1 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1,152.0 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Оны эхэнд 858.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 1.8 их наяд төгрөгийн зээлийг 3.0 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 1.4 их наяд төгрөгийн зээл төлөгдөж, 1.2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Хүснэгт 14 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Догоод
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	1,152.0	933.9	218.1	1,127.2	24.8	129.4	1,022.6	168.6	983.4
Нийт зээл	1,233.1	1,010.1	223.0	1,203.1	30.0	132.4	1,100.7	179.1	1,054.0
Хэвийн	1,072.8	863.4	209.4	1,050.0	22.9	124.4	948.5	159.2	913.6
Хугацаа хэтэрсэн	54.9	48.1	6.8	53.8	1.1	3.7	51.2	6.5	48.3
Чанаргүй:	105.4	98.5	6.9	99.4	6.0	4.4	101.0	13.3	92.0
-Хэвийн бус	21.3	18.6	2.7	20.7	0.6	1.9	19.4	2.5	18.8
-Эргэлзээтэй	25.6	23.3	2.3	24.7	0.9	1.7	23.9	2.9	22.7
-Муу	58.5	56.6	1.9	53.9	4.6	0.8	57.7	8.0	50.5
(Зээлийн эрсдэлийн сан)	81.1	76.2	4.9	75.9	5.2	3.1	78.1	10.5	70.6
Нийт зээл (төгрөгийн)	1,211.0	990.3	220.7	1,181.0	30.0	132.0	1,079.0	175.6	1,035.4
Нийт зээл (валютын)	22.1	19.8	2.3	22.1	0.0	0.4	21.7	3.5	18.6
Зээлдэгчдийн тоо	419,854	154,354	265,500	407,287	12,567	195,847	224,007	29,923	389,931

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оноос 1.0 пунктээр буурсан бол хэвийн болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ харгалзан 0.4 болон 0.7 пунктээр тус тус өссөн байна.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 160.3 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 50.6%-д 81.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.


Зураг 1 Зээлийн багцын чанар



Нийт олгосон зээлийн 65.3% буюу 1.2 их наяд төгрөг нь хэрэглээний зээлд, 12.9% буюу 230.3 тэрбум төгрөг нь худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 66.5% буюу 934.9 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлээс, 14.4% буюу 203.1 тэрбум төгрөг нь худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Олгосон зээлийн 90.6% буюу 1.6 их наяд төгрөгийн зээлийг хувь хүнд, 9.4% буюу 167.2 тэрбум төгрөгийг зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол төлөгдсөн зээлийн 90.3% буюу 1.3 их наяд төгрөг нь хувь хүнээс, 9.7% нь буюу 136.7 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

Зураг 2 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/



Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2019 оны жилийн эцсийн байдлаар 81.3 тэрбум төгрөгийн үндсэн, биет ба биет бус хөрөнгөд 14.2 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Хүснэгт 15 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	81.3	68.0	73.4	72.6	77.4	80.0	74.1	7.2	80.0
Барилга байгууламж	27.3	23.9	26.8	26.1	25.4	27.0	26.7	0.6	26.7
Техник хэрэгсэл	28.7	27.1	27.7	27.4	27.7	28.5	28.3	0.4	28.5
Тавилга эд хогшил	9.4	8.1	8.5	8.8	9.2	9.2	8.9	0.5	9.2
Дуусаагүй барилга	9.4	4.9	5.2	4.9	9.0	8.7	4.8	4.5	9.4
Биет бус хөрөнгө	6.6	3.9	5.2	5.3	6.2	6.5	5.4	1.2	6.3
(Хуримтлагдсан элэгдэл)	14.2	13.2	13.7	13.4	13.4	14.1	13.9	0.3	14.0
Барилга байгууламжийн	2.3	2.0	2.2	2.2	2.0	2.3	2.2	0.04	2.2
Техник хэрэгслийн	8.8	8.3	8.5	8.2	8.3	8.7	8.6	0.2	8.7
Тавилга эд хогшлын	3.1	3.0	3.0	3.0	3.1	3.1	3.1	0.1	3.1

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 34.7 хувиар өссөн ба энэхүү өсөлтийн 41.8 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхэнтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 16 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2018	Нийт дүнд эзлэх хувь	2019	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
	дүн		дүн		дүн	хувь
<i>Өр төлбөр</i>	307,453.8	23.9%	468,916.5	27.1%	161,462.7	52.5%
Санхүүгийн эх үүсвэр	57,607.1	4.5%	108,275.1	6.3%	50,668.0	88.0%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	151,009.6	11.8%	207,619.8	12.0%	56,610.2	37.5%
Бусад эх үүсвэр	15,668.3	1.2%	33,265.4	1.9%	17,597.1	112.3%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	23,477.8	1.8%	41,769.5	2.4%	18,291.7	77.9%
Төслийн зээлийн санхүүжилт	17,848.8	1.4%	17,556.9	1.0%	-291.9	-1.6%
Бусад өр төлбөр	41,842.2	3.3%	60,426.0	3.5%	18,583.8	44.4%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн өглөг	-	-	135.0	0.0%	135.0	-
<i>Эздийн өмч</i>	977,443.6	76.1%	1,261,217.6	72.9%	283,774.0	29.0%
Хувьцаат капитал	740,759.0	57.7%	926,992.1	53.6%	186,233.1	25.1%
Бусад өмч	10,598.7	0.8%	32,436.3	1.9%	21,837.6	206.0%
Сангууд	532.7	0.0%	641.5	0.0%	108.8	20.4%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	224,586.5	17.5%	300,311.3	17.4%	75,724.8	33.7%
Хоёрдогч өглөг	966.6	0.1%	836.6	0.0%	-130.0	-13.5%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	1,284,897.4	100.0%	1,730,134.2	100.0%	445,236.8	34.7%

Санхүүгийн эх үүсвэр

Зураг 3 Итгэлцлийн өглөг /тэрбум төгрөгөөр/



2019 оны жилийн эцсийн байдлаар итгэлцлийн үйлчилгээний дүн өмнөх оны мөн үеэс 88.0% буюу 50.7 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 34 ББСБ-аас 26 ББСБ 2,143 итгэмжлэгчээс 108.3 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна.

Улаанбаатар хотын 25 ББСБ 2,145 итгэмжлэгчээс 107.2 тэрбум төгрөг, хөдөө орон нутгийн 1 ББСБ 1 итгэмжлэгчээс 1.0 тэрбум төгрөг мөн гадаадын хөрөнгө оруулалттай 3 ББСБ 209 итгэмжлэгчээс 28.5 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 17 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

Итгэлцлийн үйлчилгээний өглөг	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	108.3	51.9	56.4	107.2	1.0	38.1	70.2	28.5
-Төгрөгөөр	83.3	49.2	34.1	82.3	1.0	20.1	63.2	19.6
-Валютаар	24.9	2.6	22.3	24.9	-	18.0	6.9	8.9
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	34	28	6	33	1	3	31	3
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	26	21	5	25	1	3	23	3
Нийт итгэмжлэгчдийн тоо	2,146	1,799	347	2,145	1	221	1925	209

Төгрөгөөр 25 ББСБ 83.3 тэрбум төгрөгийг жилийн 15.3%-ийн жигнэсэн дундаж өгөөжтэйгээр, дээд тал нь 24%, доод тал нь 8%-ийн өгөөжтэйгээр, валютаар 11 ББСБ 24.9 тэрбум төгрөгийг дээд тал нь 10%, доод тал нь 6%-ийн өгөөжтэйгээр, 6 сараас 8 жилийн хугацаатайгаар татсан байна.

Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2019 оны жилийн эцсийн байдлаар 90 ББСБ жилийн 12%-ийн жигнэсэн дундаж хүүтэйгээр, дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 207.6 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 18 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн 207.6	Нийт дүнд Эзлэх хувь	Уламжлалт 167.3	Финтек 40.4	УБ 207.2	ХОН 0.4	ХК 34.9	ХХК 172.7	ГХО 49.5	Дотоод 158.1
Хугацаагаар:										
Богино хугацаат зээл /1 жил хүртэлх/	102.0	49.1%	77.4	24.6	101.9	0.1	21.4	80.6	36.2	65.8
Урт хугацаат зээл /1 жилээс дээш/	105.6	50.9%	89.8	15.8	105.3	0.3	13.4	92.2	13.3	92.3
Валютын төрлөөр:										
Төгрөгөөр	137.8	66.4%	104.7	33.1	137.4	0.4	27.6	110.2	22.6	115.2
Валютаар	69.8	33.6%	62.6	7.2	69.8	-	7.2	62.6	26.9	42.9
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	144.2	69.4%	106.3	37.9	143.8	0.4	32.4	111.8	22.6	121.6
Зээл /төгрөгөөр/	137.8	66.4%	104.7	33.1	137.4	0.4	27.6	110.2	22.6	115.2
Зээл /валютаар/	6.4	3.1%	1.6	4.8	6.4	0.0	4.8	1.6	0.0	6.4
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	63.4	30.6%	61.0	2.5	63.4	0.0	2.5	61.0	26.9	36.5

Бусад эх үүсвэр

Хүснэгт 19 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Эзлэх хувь	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	3,991.0	12.0%	3,026.8	964.3	3,991.0	-	964.3	3,026.8	1,100.1	2,890.9
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	4,400.9	13.2%	-	4,400.9	4,400.9	-	0.0	4,400.9	-	4,400.9
Факторингийн үйлчилгээний өглөг	24,873.5	74.8%	8,134.2	16,739.3	24,873.5	-	0.0	24,873.5	-	24,873.5

2019 оны жилийн эцсийн байдлаар 6 ББСБ 4.0 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй, 1 ББСБ 4.4 тэрбум төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгтэй, 3 ББСБ 24.9 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй гарсан нь өмнөх оны мөн үеэс 3.1 дахин буюу 16.7 тэрбум төгрөгөөр өсжээ.

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.

ББСБ-аас гаргасан өрийн бичиг

2019 оны жилийн эцсийн байдлаар 29 ББСБ хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 261 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 41.8 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 20 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн 41,769,472.0	Уламжлалт 22,649,422.6	Финтек 19,120,049.5	УБ 41,640,672.0	ХОН 128,800.0	ХК 5,517,458.9	ХХК 36,252,013.1
Төгрөгөөр	39,217,678.4	21,191,036.9	18,026,641.5	39,088,878.4	128,800.0	4,424,050.9	34,793,627.5
Валютаар	2,551,793.6	1,458,385.6	1,093,408.0	2,551,793.6	0.0	1,093,408.0	1,458,385.6

Төгрөгөөр 29 ББСБ 39.2 тэрбум төгрөгийг жилийн 16%-ийн жигнэсэн дундаж хүүтэйгээр, дээд тал нь 25%, доод тал нь 6%-ийн хүүтэйгээр, валютаар 4 ББСБ 2.6 тэрбум төгрөгийг дээд тал нь 19.2%, доод тал нь 7%-ийн хүүтэйгээр, 2 сараас 12 сарын хугацаатайгаар татсан байна.

Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 39 ББСБ 17.6 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Финтек болон нээлттэй хувьцаат компаниуд төслийн зээл санхүүжилтийн үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 21 Төслийн зээл санхүүжилт /мянган төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Уламжлалт	УБ	Нийт дүнд эзлэх хувь	ХОН	Нийт дүнд эзлэх хувь	ГХО
	17,556,892.0		16,393,632.0	17,358,909.0		197,983.0		8,785,450.0
Хугацаагаар								
Богино хугацаат /1 жил хүртэлх/	4,364,452.1	24.9%	3,741,192.1	4,204,452.1	24.2%	160,000.0	80.8%	361,000.0
Урт хугацаат /1 жилээс дээш/	13,192,439.9	75.1%	12,652,439.9	13,154,456.9	75.8%	37,983.0	19.2%	8,424,450.0
Төрлөөр								
Засгийн газрын	1,005,000.0	5.7%	1,391,666.7	1,191,666.7	6.9%	160,000.0	80.8%	0.0
Гадаадын	9,506,861.8	54.1%	9,743,745.4	9,743,745.4	56.1%	0.0	0.0%	8,004,450.0
Дотоодын	6,029,006.9	34.3%	5,154,363.6	4,974,923.6	28.7%	0.0	0.0%	781,000.0
Бусад	1,016,023.2	5.8%	1,059,713.9	1,014,144.6	5.8%	37,983.0	19.2%	0.0
Валютын төрлөөр								
Төгрөгөөр	14,478,814.4	82.5%	14,133,289.5	13,708,280.2	79.0%	197,983.0	100.0%	5,530,250.0
Валютаар	3,261,913.7	18.6%	3,216,200.0	3,216,200.0	18.5%	0.0	0.0%	3,255,200.0

Бусад өр төлбөр

2019 оны жилийн эцсийн байдлаар 491 ББСБ 60.4 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүний 31.9% буюу 19.3 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, 68.1% буюу 41.1 тэрбум төгрөг нь бусад пассивын үлдэгдэл байна.

Хүснэгт 22 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн	Уламж- лалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
	60,426.0	42,925.3	17,500.6	209.3	59,542.3	883.6	13,270.7	47,155.3	14,462.0	45,964.0
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	19,291.7	12,236.3	7,055.4	0.0	19,288.9	2.9	6,265.9	13,025.8	6,481.6	12,810.1
Ангилалаар										
Зээлийн	12,044.1	7,402.1	4,642.0	0.0	12,044.1	0.1	4,533.4	7,510.7	4,718.9	7,325.2
Үнэт цаасны	446.0	134.7	311.3	0.0	445.2	0.8	138.6	307.3	0.0	446.0
Бусад	6,801.6	4,699.5	2,102.2	0.0	6,799.6	2.0	1,593.9	5,207.8	1,762.7	5,038.9
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	18,199.6	11,415.1	6,784.6	0.0	18,196.8	2.9	6,056.5	12,143.2	6,236.2	11,963.4
Валютаар	1,092.1	821.3	270.8	0.0	1,092.1	0.0	209.5	882.6	245.4	846.7
Бусад пассив	41,138.0	30,692.9	10,445.1	209.3	40,257.2	880.7	7,004.8	34,133.2	7,980.4	33,157.6

Хувь нийлүүлсэн хөрөнгө

2019 оны жилийн эцсийн байдлаар 538 ББСБ-ын 926.7 тэрбум төгрөгийн энгийн хувьцаа, 5 ББСБ-ын 728.0 сая төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 3 ББСБ-ын 476.5 сая төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 25.1% буюу 186.2 тэрбум төгрөгөөр өсөж 926.9 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт пассивын 53.6 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 23 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/

Хувьцаат капитал	Дүн	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
	926,992.1	857,706.0	69,286.0	10,254.9	894,390.2	32,601.9	28,804.8	898,187.2	89,479.8	837,512.3
Энгийн хувьцаа	926,740.5	857,188.4	69,552.1	10,254.9	894,169.2	32,571.3	29,074.5	897,666.0	89,362.4	837,378.1
Давуу эрхтэй хувьцаа	728.0	728.0	0.0	0.0	697.4	30.6	0.0	728.0	121.0	607.0
Халаасны хувьцаа	476.5	210.4	266.1	0.0	476.5	0.0	269.7	206.8	3.6	472.9

1.9 тэрбум ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 157 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 55.4% буюу 513.9 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 24 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	189.5	23	20.4%	4.3%	5.6	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	233.7	84	25.2%	15.6%	2.5	1	-	-	-	-
1.9-2.5 тэрбум	90.8	44	9.8%	8.2%	-	-	2.3	1	-	-
1.4-1.9 тэрбум	355.3	247	38.3%	45.9%	-	-	1.4	1	1.4	1
0.6-1.4 тэрбум	40.8	43	4.4%	8.0%	2.0	3	6.9	8	3.7	4
0.6 тэрбум хүртэлх	17.0	97	1.8%	18.0%	3.3	8	8.6	52	5.2	38
НИЙТ	927.0	538	100.0%	100.0%	13.4	13	19.2	62	10.3	43

Харин 1.9 тэрбум хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 387 ББСБ-ын 413.1 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 44.6 хувийг бүрдүүлж байна.

Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 3.1 дахин өссөн байна. Энэхүү өсөлт нь нийтэд нээлттэй хувьцаагаа санал болгосон 3 ББСБ-ын нэмж төлөгдсөн капиталын өсөлтөөс 100.0% хамаарч байна.

Хүснэгт 25 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
Бусад өмч	32,436.3	10,142.5	22,293.8	95.4	32,026.5	409.8	22,293.8	10,142.5	16,337.4	16,098.9
Нэмж төлөгдсөн капитал	28,189.1	5,952.7	22,236.5	77.7	28,041.2	147.9	22,236.5	5,952.7	16,331.7	11,857.4
Дахин үнэлгээний нэмэгдэл	2,014.2	2,014.2	-	-	1,886.5	127.7	-	2,014.2	5.7	2,008.5
Хандивын капитал	2,232.9	2,175.6	57.3	17.8	2,098.7	134.2	57.3	2,175.6	-	2,232.9
Сангууд	641.5	641.5	-	-	77.6	563.8	-	641.5	3.4	638.0
Нооцийн сан	421.5	421.5	-	-	7.5	413.9	-	421.5	-	421.5
Нийгмийн хөгжлийн сан	220.0	220.0	-	-	70.1	149.9	-	220.0	3.4	216.6

Хуримтлагдсан ашиг/алдагдал

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 33.7% буюу 75.7 тэрбум төгрөгөөр өсөж 300.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Хүснэгт 26 Хуримтлагдсан ашиг/алдагдал

	АШИГ/АЛДАГДАЛ						
	ХУРИМТЛАГДСАН			-Тухайн үеийн		-Хуримтлагдсан	
2018	224,586,513.1			101,131,273.6		123,455,239.6	
2019	300,311,262.1			140,168,365.2		160,142,897.0	
	ББСБ тоо	Дүн	ББСБ тоо	Дүн	ББСБ тоо	Дүн	ББСБ тоо
Уламжлалт	527	266,253,685.5	522	116,037,087.7	517	150,216,598.0	464
Финтек	11	34,057,576.4	11	24,131,277.5	11	9,926,298.9	10
ЗГВА	43	836,766.9	43	133,922.9	42	702,844.1	43
УБ	463	296,216,352.7	461	136,190,741.0	457	160,025,612.0	416
ХОН	75	4,094,909.2	72	3,977,624.2	71	117,285.0	58
ХК	4	20,746,301.8	4	17,315,512.3	4	3,430,789.5	4
ХХК	534	279,564,960.1	529	122,852,852.9	524	156,712,107.4	470
ГХО	28	26,227,678.3	28	20,711,486.3	28	5,516,192.0	25
Дотоод	510	274,083,583.6	505	119,456,878.8	500	154,626,705.0	449

Хоёрдогч өглөг

Өмнөх оны мөн үед 6 ББСБ 966.6 сая төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байсан бол 1 ББСБ-ын 130.0 сая төгрөгийн хоёрдогч өглөг хасагдаж 2019 оны жилийн эцсийн байдлаар 5 ББСБ 836.6 сая төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байна.


Хүснэгт 27 Хоёрдогч өглөг /сая төгрөгөөр/

ББСБ-ын нэр	2018	2019	Хувь
1. "Алтан төгрөг ББСБ" ХХК	171.6	171.6	17.7%
2. "Роял финанс ББСБ" ХХК	70.0	70.0	7.2%
3. "Актив мөргөйж фанд ББСБ" ХХК	100.0	100.0	10.3%
4. "Марико ББСБ" ХХК	195.0	195.0	20.2%
5. "Эн Ви Си ББСБ" ХХК	300.0	300.0	31.0%
6. "Ди Эй Эм Оү Эй" ХХК	130.0	-	13.4%
Нийт дүн	966.6	836.6	100%

Ашигт ажиллагаа

2019 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 352.9 тэрбум төгрөгийн орлого олж, 212.8 тэрбум төгрөгийн зардал гаргаж 140.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 4 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 36.0% буюу 93.4 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 34.3% буюу 54.4 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 38.6% буюу 39.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 28 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/

ОРЛОГО	2018	2019	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	217,428.2	292,253.8	82.8%	74,825.6	34.4%
Хүүгийн бус орлого	33,485.5	53,859.1	15.3%	20,373.6	60.8%
-Санхүүгийн үйлчилгээний орлого	20,262.2	41,388.4	11.7%	21,126.2	104.3%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	2.8	2.2	0.0%	-0.7	-23.1%
- Мөнгөн гуйвуулгын орлого	1,332.3	1,008.3	0.3%	-324.0	-24.3%
- Картын үйлчилгээний орлого	0.0	2,136.5	0.6%	2,136.5	-
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	155.3	257.2	0.1%	101.9	65.6%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	13,262.2	30,537.0	8.7%	17,274.8	130.3%
- Бусад	5,509.5	7,447.2	2.1%	1,937.7	35.2%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	8,582.8	6,807.9	1.9%	-1,774.9	-20.7%
НИЙТ ОРЛОГО	259,496.4	352,920.8	100.0%	93,424.3	36.0%
ЗАРДАЛ					
Хүүгийн зардал	20,605.6	36,127.7	17.0%	15,522.1	75.3%
Хүүгийн бус зардал	95,960.2	117,961.6	55.4%	22,001.4	22.9%
Болзошгүй эрсдэлийн зардал	23,965.2	34,253.4	16.1%	10,288.3	42.9%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	3,876.8	3,718.8	1.7%	-158.0	-4.1%
Орлогын албан татварын зардал	13,957.4	20,690.9	9.7%	6,733.5	48.2%
НИЙТ ЗАРЛАГА	158,365.2	212,752.4	100.0%	54,387.2	34.3%
АШИГ					
ЦЭВЭР ОРЛОГО	101,131.3	140,168.4	100.00%	39,037.09	38.6%

Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд хүүгийн бус орлого 60.8% буюу 20.4 тэрбум төгрөгөөр өссөн ба энэ нь үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого 2.3 дахин өссөнтэй холбоотой. Финтек буюу санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн,

шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээ үзүүлэгч ББСБ-ууд зээлдэгчдийн хэрэглээнд зориулсан бичил зээл олгохдоо ихэвчлэн хүү тогтоохгүйгээр, шимтгэл авч байгаа нь энэхүү орлогыг нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн байна. Нийт үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлогын 81.3% буюу 24.8 тэрбум төгрөгийг финтек үйлчилгээ үзүүлж буй ББСБ-уудын орлого бүрдүүлж байна.

Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь хүүгийн зардал байна. Хүүгийн зардал нь 75.3% буюу 15.5 тэрбум төгрөгөөр өсжээ.

Нийт зардлын өсөлтийн 40.5 хувийг хүүгийн бус зардлын өсөлт бүрдүүлж байна. Хүүгийн бус зардал нь өмнөх оны мөн үеэс 22.9% буюу 22.0 тэрбум төгрөгөөр өсөж 118.0 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт зардлын 55.4 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 29 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Догоод
Хүүгийн орлого	292,253.8	250,641.4	41,612.4	14.6	284,542.3	7,711.5	23,995.0	268,258.8	49,335.2	242,918.6
Хүүгийн бус орлого	53,859.1	26,703.8	27,155.3	1,222.5	53,269.0	590.1	22,339.0	31,520.1	5,574.1	48,285.0
- Санхүүгийн үйлчилгээний орлого	41,388.4	15,941.7	25,446.7	3.4	40,842.0	546.4	21,115.7	20,272.7	3,989.0	37,399.4
Итгэлцлийн үйлчилгээний орлого	2.2	-	2.2	-	2.2	-	-	2.2	-	2.2
Мөнгөн гуйвуулгын орлого	1,008.3	1,008.3	-	-	1,008.3	-	-	1,008.3	14.3	994.0
Картын үйлчилгээний орлого	2,136.5	2,136.5	-	-	2,136.5	-	-	2,136.5	-	2,136.5
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	257.2	257.2	-	-	257.2	-	-	257.2	-	257.2
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	30,537.0	5,713.8	24,823.2	-	30,126.4	410.6	20,496.8	10,040.2	1,408.4	29,128.6
Бусад	7,447.2	6,825.8	621.4	3.4	7,311.4	135.8	618.9	6,828.3	2,566.3	4,880.9
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6,807.9	5,575.3	1,232.6	0.0	6,461.0	346.9	1,231.9	5,576.0	1,939.2	4,868.6
НИЙТ ОРЛОГО	352,920.8	282,920.6	70,000.2	1,237.1	344,272.2	8,648.5	47,565.9	305,354.9	56,848.5	296,072.2
ЗАРДАЛ										
Хүүгийн зардал	36,127.7	27,257.7	8,870.0	-	35,924.4	203.3	5,870.1	30,257.6	7,005.6	29,122.1
Хүүгийн бус зардал	117,961.6	91,932.1	26,029.4	1,077.2	114,793.5	3,168.0	16,375.9	101,585.7	20,257.4	97,704.2
Болзошгүй эрсдэлийн зардал	34,253.4	28,986.8	5,266.6	-	33,518.6	734.9	3,614.6	30,638.8	4,027.7	30,225.7
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	3,718.8	2,995.7	723.1	3.3	3,611.7	107.1	334.9	3,383.9	519.6	3,199.2
Орлогын албан татварын зардал	20,690.9	15,711.2	4,979.7	22.8	20,233.3	457.6	4,054.8	16,636.0	4,326.7	16,364.1
НИЙТ ЗАРЛАГА	212,752.4	166,883.5	45,868.9	1,103.2	208,081.5	4,670.9	30,250.3	182,502.1	36,137.1	176,615.3
АШИГ										
ЦЭВЭР ОРЛОГО	140,168.4	116,037.1	24,131.3	133.9	136,190.7	3,977.6	17,315.5	122,852.9	20,711.5	119,456.9

Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын 14.6 сая төгрөгийн хүүгийн орлогыг 6 ББСБ-ын банкин дахь харилцах дансны хүүгийн орлого бүрдүүлж байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 538 ББСБ-ын 85.3% буюу 459 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 14.7% нь буюу 79 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 58 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 18 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг Хорооны 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 210 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Үүний дагуу ББСБ-уудын ЗХШҮ-ийг үйл ажиллагааны төрлөөс хамааруулан өөрөөр тогтоосон байсныг нэг болгосон бөгөөд ингэхдээ гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг болон итгэлцлийн үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-уудад холбогдох харьцаа үзүүлэлт хамаарахгүй байхаар тусгасан.

Хүснэгт 30 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/

№	Эрхлэх үйл ажиллагааны төрөл	Хангах шаардлагатай ББСБ-ын тоо	Итгэлцэл	34	Итгэлцэлээс бусад	461	ЗГВА	43	Нийт	538
	Хангасан	Хангаагүй	√	X	√	X	√	X	√	X
Хангах шаардлагатай ЗХШҮ-ийн тоо		Хангаагүй ЗХШҮ-ийн тоо	18	7	17	10	6	5	18	12
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа		33	1	446	15	41	2	520	18
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа		33	1	441	20	42	1	516	22
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа		34	-	458	3	42	1	534	4
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа		32	2	450	11	43	-	525	13
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ишүү,- дутуу)		34	-	-	-	-	-	-	-
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа		33	1	454	7	-	-	530	8
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа		34	-	461	-	-	-	538	-
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дунгийн зохистой харьцаа		33	1	460	1	-	-	536	2
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа		34	-	457	4	XXX	-	534	4
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа		34	-	461	-	-	-	538	-
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа		34	-	461	-	-	-	538	-
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “ИГ” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа		34	-	461	-	-	-	538	-
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа		34	-	460	1	-	-	537	1
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа		33	1	460	1	-	-	536	2
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа		34	-	452	9	39	4	525	13
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа		34	-	XXXXX	-	XXX	-	538	-
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа		34	-	461	-	-	-	538	-
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа		33	1	446	15	42	1	521	17

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцааг 22 ББСБ, Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцааг 18 ББСБ, Үндсэн хөрөнгийн зохистой харьцааг 17 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

Дүгнэлт

2019 оны жилийн эцсийн тайлан мэдээг ирүүлбэл зохих 538 ББСБ-аас 520 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 18 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

2019 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 7,712 хувь нийлүүлэгчдийн 538 ББСБ, 250 салбар нэгж, 7 төлөөлөгчийн газар, 2,962 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт 2,854,530 харилцагч, 419,854 зээлдэгчид хүрч үйлчилж байна. ББСБ-уудыг төвлөрлөөр авч үзвэл 463 ББСБ, 176 салбар Улаанбаатар хотод, 75 ББСБ, 74 салбар хөдөө орон нутагт бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын актив 1.7 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 34.7 хувиар буюу 445.2 тэрбум төгрөгөөр өсжээ.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 2.5 тэрбум хүртэл хөрөнгөтэй 392 ББСБ нийт активын 29.4 хувийг, 2.5 тэрбум ба түүнээс дээш хөрөнгөтэй 146 ББСБ нийт активын 70.6 хувийг бүрдүүлж байна.

Салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын зээлийн өрийн үлдэгдлийн 6.9 хувьтай тэнцэж байгаа бөгөөд үүний 1,072.8 тэрбум төгрөг буюу 87.0 хувийг хэвийн зээл, 54.9 тэрбум төгрөг буюу 4.5 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 105.4 тэрбум төгрөг буюу 8.5 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 160.3 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 50.6%-д 81.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оноос 1.0 пунктээр буурсан бол хэвийн болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ харгалзан 0.4 болон 0.7 пунктээр тус тус өссөн байна.

Тайлант жилд 1.6 их наяд төгрөгийн зээлийг сарын 3.0 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгосон нь банкны салбартай харьцуулахад 1.4 пунктээр өндөр байна.

ББСБ-уудын пассивын бүтцийг харвал 27.1% буюу 468.9 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 72.9% буюу 1.3 их наяд төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 107 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 45.6 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.4-2.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 291 ББСБ 48.1 хувийг эзэлж байгаа бол 1.4 тэрбумаас доош хөрөнгөтэй 140 ББСБ 6.2 хувийг бүрдүүлж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 352.9 тэрбум төгрөгийн орлого олж, 212.8 тэрбум төгрөгийн зардал гаргаж 140.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт ББСБ-ын 85.3% буюу 459 ББСБ зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан бол үлдэх 14.7% нь буюу 79 ББСБ зохистой харьцааны зарим үзүүлэлтийг хангаагүй байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР